

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2023/73/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2023 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

Төсвийн хөрөнгөөр 19.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, дээд газраас нь 46.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө ирсэн байна. Соёлын яамнаас бүтэц орон тоог батлан, үндсэн үйл ажиллагаанд нь чиглэл өгч ажиллаж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь оны эхнээс шинээр байгуулагдсан боловч үйл ажиллагаа нь жигдрээгүй байна. Соёлын яамнаас баталсан бүтэц орон тоогоор ажиллаж байгаа боловч Төрийн захиргааны алба хаагчид нь төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй тул Төрийн үйлчилгээний цалингийн шатлалаар цалинжиж ирсэн байна.

Төсөв хариуцсан мэргэжилтэн байхгүй, төсөв зарцуулалтад 1,2-р гарын үсэг зурж байгаа дарга, нягтлан бодогч нар санхүү, бүртгэлийн хувьд хангалтгүй ажиллаж ирсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

The image shows an official stamp of the State Audit Agency of Mongolia. The stamp is rectangular and contains the Mongolian text 'МОНГОЛ УЛСЫН АУДИТ АГЫН ТӨСВИЙН АУДИТОР' (State Audit Agency of Mongolia, State Auditor). Overlaid on the stamp is a handwritten signature in black ink.

О БАТЖАРГАЛ

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 6.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч албан шаардлага өгсөн, аудитын явцад 2.5 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Сумдын Соёлын төв, мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын салбарын 2022 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан хэлэлцэх сургалтын арга хэмжээ зохион байгуулж бараа үйлчилгээний бусад зардлаас хоол болон хулдаасан хэвлэл хийлгэхэд 6.1 сая төгрөг зарцуулсан байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Аймгийн Соёл, урлагийн газар	1	2.5			1	2.5	1	2.5				
Дүн	1	2.5			1	2.5	1	2.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн Соёл, урлагийн газар	1	6.1			1	6.1						
Дүн	1	6.1			1	6.1						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ								



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР